

УЛААНБААТАР ХОТЫН МУЗЕЙН 2026 ОНЫ 1-Р УЛИРЛЫН ҮНДСЭН ЧИГ ҮҮРГИЙН ТАЙЛАН

Тодруулга мэдээлэл авах: Улаанбаатар хотын музей

Менежер Б.Нарангэрэл, утас: 11-456799

№	Арга хэмжээ	Хүрэх түвшин	Тайлбар
БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ:Түүх соёлын өвийг бүртгэлжүүлж, түүх соёлын дурсгалт газруудыг хамгаалалтад авч, засварлан тохижуулж, соёл, амралт, аялал жуулчлалын бүс болгон соёлын аялал жуулчлалыг дэмжинэ. /НЗДҮАХ 2.4.1/			
1.Виртуал технологийг ашиглан музей, түүх соёлын өвийн санг бий болгон ухаалаг аялал жуулчлалыг хөгжүүлнэ. /НЗДҮАХ-2.4.1.3/			
1	Арга хэмжээ 1.1 Нийслэлийн Бизнесийг дэмжих жил болгон зарласантай уялдуулан “Музейн үзүүлэгийг шинэчлэн дэглэж, үзмэрийг дижитал (AR, QR, Touch screen display) хэлбэрт шилжүүлэх төсөл” боловсруулж батлуулах арга хэмжээг авна.	Төсөв батлуулах (300 сая)	Нийслэлийн Засаг даргын 2026 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн А/333 дугаартай захирамжийн хавсралтаар батлагдсан “Улаанбаатар хотын музейн барилгыг сэргээн засварлан хүчитгэж, гадна орчин, ногоон байгууламжийг тохижуулах төсөл”-ийн зураг төсөл, төсөв) 450 сая төгрөгийн дүнтэй батлагдсан.
2	Арга хэмжээ 1.2 “Соёлын өвийн нэгдсэн бүртгэл мэдээллийн систем” буюу Web-д суурилсан шинэ бүртгэлийн программ музейн түүх соёлын хөдлөх дурсгалт зүйлийг тогтмол бүртгэн баримтжуулна.	Музейн бүх үзмэрийг баримтжуулах	2024 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн Соёлын Өвийн Үндэсний Төвийн А/41 дүгээр тушаалын Соёлын өвийг бүртгэх “Соёлын өвийн нэгдсэн бүртгэл, мэдээллийн систем” ашиглахтай холбогдуулан “Бүртгэл, хөтлөх, ашиглах, аргачлал”-ын дагуу музейн нийт 3546 үзмэрийг Web-д суурилсан шинэ бүртгэлийн программд үзмэрийн нэр, хувийн дугаар, тодорхойлолт, баримтжуулалтын зургийг нэг бүрчлэн оруулан бүртгэлийн ажлыг хийж дуусгасан. https://ncch.cis.mn/auth/login
Үзэсгэлэн			

3	Түүхэн тэмдэглэлт үйл явдал, цаг үеийн холбогдолтой түр, явуулын, сэдэвчилсэн үзэсгэлэнг зохион байгуулна.	Музейн байранд 2-с доошгүй, явуулын 5-с доошгүй үзэсгэлэн зохион байгуулна	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 96 дугаар тогтоол “Монголчуудын төрт ёсны уламжлал, түүх, соёлын дурсгалт зүйл, уран зохиол, урлагийн бүтээлээр хүүхэд залуучуудад үндэсний бахархал, эх оронч үзлийг төлөвшүүлэх зорилгоор жил бүрийн 3 дугаар сарын эхний 7 хоногт “Музейн нээлттэй өдрүүд” арга хэмжээг зохион байгуулж байхыг” даалгасны дагуу Улаанбаатар хотын түүхэн үечлэл үзэсгэлэнг зохион байгуулав. НСУГ-тай хамтран “Улаанбаатарын хавар 2026” арга хэмжээнд Нийслэл хот гэрэл зурагт” гэрэл зураг, леги үзэсгэлэнг зохион байгуулав. Улаанбаатар хотын музейгээр 1-р улиралд 71 том хүн, 132 хүүхэд, 253 оюутан, 5 гадаад иргэн буюу нийт 461 хүн үйлчлүүлсэн. Явуулын гэрэл зургийн үзэсгэлэнгээр 2863 том, 1616 хүүхэд, 1208 оюутан, 298 гадаад иргэн, 228 ахмад настан, 37 хөгжлийн бэрхшээлтэй иргэд буюу 6250 хүн үзэж сонирхсон.
Соён гэгээрүүлэх, боловсролын хөтөлбөр			
4	Засгийн газрын “Боловсролыг дэмжих жил”-Иргэд болон зорилтот бүлэгт чиглэсэн олон талт боловсролын хөтөлбөр хэрэгжүүлж хотын түүх, соёлыг түгээж, хүртээмжийг нэмэгдүүлнэ.	4 төрлийн хөтөлбөрийн хүрээнд 1200-1500 хүүхэд залуусд хүрч үйлчлэх	1-р улирлын байдлаар 4 төрлийн боловсролын хөтөлбөрийн хүрээнд 28 удаагийн давтамжтайгаар 402 хүнд хүрч үйлчилсэн. Боловсролы хөтөлбөр: <ul style="list-style-type: none"> - “Дугуйт найзтай танилцъя” боловсролын хөтөлбөр - “Улаанбаатар хотын үл хөдлөх дурсгал” боловсролын хөтөлбөр - Арслан заан савагт хирстэй танилцъя - Соёлтой хот, соёлтой иргэн-үе тэнгийн дээрэлхэлт
5	Засгийн газрын “Боловсролыг дэмжих жил”- Иргэд болон байгууллагуудад Улаанбаатар хотын түүх сэдвээр лекц зохион байгуулна.	7-с доошгүй лекц зохион байгуулж, 100 гаран хүнийг хамруулна.	Тайлант хугацаанд хотын түүх, соёлыг сурталчлан таниулах нийт 5 удаагийн лекцэнд 302 хүн хамрагдав. 2025.12.22-нд Ремакс үл хөдлөх хөрөнгийн зууч компанийн 46 ажилтанд “Улаанбаатар хотын түүх:

			<p>Түүхэн орон зай ба барилга, архитектур” сэдвээр Гэгээнтэнд оффист лекц уншив.</p> <p>2026.01.14-нд Гайд төвөөс зохион байгуусан хөтөч тайлбарлагчийн сургалтад хамрагдсан 25 суралцагчдад “Бид ямар түүхтэй хотод амьдардаг вэ?” сэдвээр лекц уншив.</p> <p>2026.02.03-нд Чойжин ламын сүм музейн хашаан дахь Аялал жуулчлалын мэдээллийн төвд Гайд төвийн 13 суралцагчдад “Нүүдлийн соёлыг шингээсэн хот” сэдэвт лекц уншив.</p> <p>2026.02.07-нд АВ travel компанийн солонгос хэлний 18 гайдад “Бид ямар түүхтэй хотод амьдардаг вэ” лекцийг Sav plaza-д уншив.</p> <p>2026.02.06-нд Этүгэн их сургуулийн анагаахын нэгдүгээр ангийн 200 оюутанд “Бид ямар түүхтэй хотод амьдардаг вэ” лекцийг тус сургуулийн сургалтын танхимд уншив.</p>
Үзмэрийн хадгалалт, хамгаалалт			
6	Бизнесийг дэмжих жил - Музейн сан хөмрөгийн өрөө, үзүүллэгийн танхимын орчин нөхцөлийг сайжруулах ажлыг зохион байгуулна.	4 ажлыг хийж хэрэгжүүлнэ.	<p>Музейн хадгалалт хамгаалалт сайжруулж эрсдэлээс хамгаалах ажлын хүрээнд 4 арга хэмжээ зохион байгуулан ажиллаж байна. Үүнд:</p> <p>1.Тайлант хугацаанд хадгалалт хамгаалалттай холбоотой 10 баримт бичиг боловсруулсан.</p> <p>2. Ариутгал халдваргүйжүүлэлт хийлгэх “Хан судар” ХХК тай 2026 онд хамтран ажиллах гэрээг 2026 оны 02 дугаар сарын 03 ны өдөр байгуулсан.</p> <p>3. Музейн дүрэм журам зааврын дагуу “Сан хөмрөгийн түлхүүр хүлээлцэх бүртгэл”, “Сан хөмрөгт орсон гарсан бүртгэл” хөтөлөх ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд: Тайлант хугацаанд “Сан хөмрөгийн түлхүүр хүлээлцэх бүртгэл”, “Сан хөмрөгт орсон гарсан бүртгэл”-ийг нийт 14 удаа тэмдэглэл хөтлөн ажилсан.</p> <p>4. Музейн сан хөмрөгийн өрөөний үзмэрийн арчилгаа цэвэрлэгээ, гэрэлтүүлэг, чийг дулааныг хэмжих хуваарь гарган батлуулж тогтмол хэмжилт хийж бүртгэл хөтлөх ажиллаж байна. Музейн үзүүллэгийн танхимыг нийт 2 удаа цэвэрлэгээ хийсэн. Музейн 1-р танхимд</p>

			хадгалагдаж буй UBM82.2 “Л.И.Брежнев”, UBM74.2 “Түүхт Улаанбаатар” үзмэрт цэвэрлэгээ хийсэн. /зураг 1/
7	Музейн үзмэрийг арчлан тордох, сэргээн засварлуулах, хадгалалтын нөхцөлийг сайжруулах ажлыг зохион байгуулна.	40-с доошгүй үзмэрийн нөхцөлийг сайжруулах, 5 үзмэрийг сэргээн засварлуулна.	Үзмэрүүдийн хадгалалтын нөхцөлийг сайжруулах ажлын хүрээнд шаардлагатай хамгаалалтын хэрэгсэл, материалыг худалдан авах гэрээ хийгдсэн ба хангамж хийгдээгүй байгаа тул 2-р улирлаас хийгдэж эхэлнэ, СӨҮТ-д сэргээн засварлуулах үзмэрийн жагсаалтыг саналыг 2025 онд хүргүүлснээр 2026 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 05/43 дугаар албан бичгээр албан ирсэн. Үүний дагуу 5 дэсийн 5 ширхэг үзмэрийг Соёл, Спорт Аялал Жуулчлал Залуучуудын сайдын 2026 оны А/108 дугаар тушаалаар соёлын биет өвийг зөөж тээвэрлэх зөвшөөрөл гаргуулан СӨҮТ-д сэргээн засварлуулахаар хүлээлгэн өгөөд байна.
Эрдэм шинжилгээ судлагааны ажил			
8	“Улаанбаатарын мэдээ” сонины эмхэтгэлийн 3 дугаар ботийг хэвлүүлж, олны хүртээл болгоно.	100 ширхэг ном хэвлүүлнэ.	Тайлант хугацаанд сэтгүүлд эрдэм шинжилгээний нийтлэл хэвлүүлэх, номд зохиогчоор оролцох, ном редакторлах, виртуал контентын баримт бэлтгэх зэрэг судалгаа, шинжилгээний ажлыг гүйцэтгэв. -Музейн танхим дахь 11 үзмэрийн хаяг тайлбарыг “Музейн хаяг тайлбар бичих журам”-ын дагуу гаргаж, байрлуулсан. -Үзмэрийн хаяг тайлбарыг монгол бичигтэйгээр гаргах эхийг бэлтгэсэн. -Музейн захирлын тушаалаар батлагдсан 2026 онд эрдэм шинжилгээ, судалгаа хийх үзмэрийн жагсаалтын дагуу 82, 83, 84, 89, 90 дэс дугаартай 5 үзмэрийн түүхийг судалгааг хийсэн.
Мэдээлэл сурталчилгаа			

9	Музейн цахим хуудас, веб сайтаар дамжуулан иргэдэд хотын түүхийн талаар танин мэдэхүйн мэдлэг олгох цуврал мэдээллүүдийг бичлэгээр хүргэнэ.	10 төрлийн мэдээллийг сонирхолтой хэлбэрээр хүргэнэ.	<p>Улаанбаатар хотын музейн 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний “3.9.2 Нийслэл болон музейгээс зохион байгуулсан арга хэмжээнүүдийг байгууллагын олон нийтийн цахим сувгуудаар /инстаграм, фейсбүүк/ дамжуулан олон нийтэд хүргэнэ” гэсэн зорилтын хүрээнд нийт 11 мэдээллийг бэлтгэн цахим хуудсуудад нийтэлсэн.</p> <p>Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - 02-р сарын 04-нд БЗД-ийн 115-р цэцэрлэгийн ахлах бүлгийн хүүхдүүдэд “Дугуйт найзтай танилцъя” боловсролын хөтөлбөрийг зохион байгуулсан тухай мэдээлэл - 02-р сарын 28-нд Музейн байршлыг заасан богино бичлэг - 03-р сарын 01-нд “Музейн нээлттэй өдрүүд-2026” 1 дэх өдрийн мэдээлэл - 03-р сарын 02-нд “Музейн нээлттэй өдрүүд-2026” 2 дахь өдрийн мэдээлэл - 03-р сарын 03-нд “Музейн нээлттэй өдрүүд-2026” 3 дахь өдрийн мэдээлэл - 03-р сарын 04-нд “Музейн нээлттэй өдрүүд-2026” 4 дэх өдрийн мэдээлэл - 03-р сарын 05-нд “Музейн нээлттэй өдрүүд-2026” 5 дахь өдрийн мэдээллийг богино бичлэг хэлбэрээр бэлтгэн нийтэлсэн. - 03-р сарын 06-нд “Музейн нээлттэй өдрүүд-2026” 6 дахь өдрийн мэдээлэл - 03-р сарын 07-нд “Музейн нээлттэй өдрүүд-2026” 7 дахь өдрийн мэдээлэл - 03-р сарын 08-нд Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийн мэндчилгээг бэлтгэн нийтэлсэн. - 03-р сарын 09-нд Жендэрийн эрх тэгш байдлыг хангах хуулийн хэрэгжилтийн хүрээнд “Харилцан хүндэтгэе” аянд нэгдэж буйг илэрхийлсэн постер бэлтгэн нийтэлсэн. <p>Холбогдох линк: https://www.facebook.com/UlaanbaatarCityMuseum/</p>
---	---	--	--

			https://www.instagram.com/ulaanbaatarcitymuseum/?hl=en Нийт хандалтын тоо: 35,603
--	--	--	--

Тодруулга мэдээлэл авах: Улаанбаатар хотын музей

Менежер Б.Нарангэрэл, утас: 11-456799